

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



“СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2026 ОНЫ НӨХӨН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ НАМ, ЭВСЭЛ, БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨРТ ДҮГНЭЛТ ГАРГАХ” АУДИТЫН ТАЙЛАН

СУМДЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2026 ОНЫ НӨХӨН
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ НАМЫН ХОРОО, БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧИЙН МӨРИЙН
ХӨТӨЛБӨР НЬ ХОЛБОГДОХ ХУУЛЬ, ТОГТООМЖИД НИЙЦСЭН БАЙНА

АУДИТЫН КОД: ХӨА-2026/104-ШТА-НА

Хөвсгөл аймаг
2026 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх
аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: З.Даваадорж

Утас: 91890258 Цахим хаяг: davaadorjz@audit.gov.mn

Аудитор: Н.Гүрбазар

Утас: 99979050 Цахим хаяг: gurbazarn@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу.
<https://open.audit.mn/report>

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:

Хөвсгөл аймаг дахь
Төрийн аудитын газар

Тэргүүлэх аудитор

А.Эрдэнэбаатар

Аудитын менежер

Б.Тэгшдэлгэр

Ахлах аудитор

З.Даваадорж

Аудитор

Н.Гүрбазар

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж тодруулах,
асууж лавлах зүйл гарвал
70384043 дугаарын утас,
70383793 дугаарын
факсаар харилцана уу.

ХАЯГ: Мөрөн сум Аймгийн
ЗДТГ-ын “А” корпус 3
давхар

Цахим хаяг:

audit.mn/?page_id=579

2026 оны 05 дугаар сар

Товчилсон үгийн жагсаалт

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Ерөнхий мэдээлэл

Бүлэг А. Сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцох намын хороо, бие даан нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөр нь холбогдох хууль, тогтоомжид нийцсэн байна.

Дүгнэлт

Хавсралтууд

Товчилсон үгийн тайлбар

Товчилсон үг	Тайлбар
АИТХ	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ҮАГ	Үндэсний Аудитын Газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ТУШААЛ**

2026 оны 05 сарын 15 өдөр

Дугаар A/19

Мөрөн сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол улсын Ерөнхий аудиторов 2025 оны “Эрх шилжүүлэх тухай” А/175 дугаар тушаалын гуравдугаар хавсралтаар баталсан “Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх”-ийн 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцох нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрт дүгнэлт гаргах” аудитын тайланг хавсралтаар баталгаажуулсугай.
2. Аудитын ажлын болон нотлох баримтыг 2026 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор архивын нэгж болгон архивд хүлээлгэн өгөхийг аудитын баг (ахлах аудитор З.Даваадорж)-т үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер(Б.Тэгшдэлгэр)-т даалгасугай.



А.ЭРДЭНЭБААТАР

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрх, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, 37.8, МҮЕА-ын 2026 оны А/32 дугаар тушаал, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторовын баталсан Төрийн аудитын газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн гүйцэтгэв.

2. Аудитын зорилт:

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, 37.8-д заасны дагуу МҮЕА-ын 2024 оны А/49 дүгээр тушаалаар тушаалаар баталсан “Аймаг нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт аудит хийж, дүгнэлт гаргах аргачлал” дагуу нам, эвсэл, бие даан нэр дэвшигчдээс ирүүлсэн мөрийн хөтөлбөрт дүгнэлт гаргаж олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэнэ. Үүнд:

- Сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцох нам эвсэл, бие даан нэр дэвшигчдийн Мөрийн хөтөлбөр холбогдох хууль тогтоомжуудад нийцсэн эсэхэд дүгнэлт гаргаж олон нийтэд мэдээлэх.

3. Аудитын хамрах хүрээ:

Аудитад Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ, Тариалан сумдын ИТХ-ын 2026 оны нөхөн сонгуульд оролцох нам, эвсэл, бие даан нэр дэвшигчдээс ирүүлсэн мөрийн хөтөлбөрийг хамрууллаа.

4. Аудитын арга зүй:

МҮЕА-ын 2024 оны А/49 дүгээр тушаалаар баталсан “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт аудит хийж, дүгнэлт гаргах аргачлал”-ын дагуу нам, эвсэл, бие даан нэр дэвшигчдээс аудитад шаардагдах судалгаа баримт, мэдээлэл, гаргуулан авч, ирүүлсэн нотлох зүйлс, судалгаа мэдээллийг нягтлан шалгаж, нэгтгэх үнэлэх зэрэг горим арга зүйг ашиглана.

5. Ашиглах шалгуур үзүүлэлтүүд:

Аудит хийх ажлын зорилттой холбоотой дараах хууль, тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур үзүүлэлт болгон ашиглана. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль;
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль;
- Улс төрийн намын тухай хууль;
- Монгол улсын Ерөнхий аудиторовын 2024 оны А/49 дүгээр тушаалаар баталсан Заавар, аргачлал
- Холбогдох бусад хууль, тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, стандарт;

6. Аудитын багийн бүрэлдэхүүн:

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар хянан удирдаж, аудитын менежер Б.Тэгшдэлгэр аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор З.Даваадорж, аудитор Н.Гүрбазар нар хийж гүйцэтгэлээ.

7. Үндсэн мэдээлэл:

Орон нутгийн хурлын 2026 оны нөхөн сонгуулиар Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ, Тариалан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тус бүр 1 суудал/мандат/-ыг нөхөхөөр Сонгуулийн ерөнхий хорооноос тогтоож, цаг хугацааны хуваарийг баталж нөхөн сонгуулийг 2026 оны 06 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулахаар болсон байна. Сонгуулийн

ерөнхий хорооноос баталсан цаг хугацааны хуваарьт Төрийн аудитын газар нь нөхөн сонгуульд оролцох нам, эвслийн мөрийн хөтөлбөрт 2026 оны 04 дүгээр сарын 22-ны өдрөөс өмнө, бие даан нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрт 2026 оны 05 дугаар сарын 17-ны өдрөөс өмнө тус тус хууль, журамд заасны дагуу хяналт хэрэгжүүлж, дүгнэлт гарган нам, эвсэл, бие даан нэр дэвшигч, холбогдох сонгуулийн хороонд хүргүүлэхээр заасан байна.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийг Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.12¹-т заасны дагуу санал авах өдрөөс 22 хоногийн өмнөөс эхлэн энэ хуульд заасны дагуу нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлангаа хүргүүлэх өдрийг дуустал өөрийн байгууллагын цахим хуудаст нээлттэйгээр байршуулна.

БҮЛЭГ А:

СУМДЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2026 ОНЫ НӨХӨН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ НАМЫН ХОРОО, БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР НЬ ХОЛБОГДОХ ХУУЛЬ, ТОГТООМЖИД НИЙЦСЭН БАЙНА.

Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ, Тариалан сумын ИТХ-ын 2026 оны нөхөн сонгуульд оролцохоор Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.8²-д заасан хугацаанд мөрийн хөтөлбөрт дүгнэлт гаргуулахаар дараах сумын намын хороо, бие даан нэр дэвшигч Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт мөрийн хөтөлбөрөө ирүүлсэн байна. **Үүнд:**

1. Хөвсгөл аймгийн Тариалан сумын Монгол ардын намын хороо,
2. Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын ИТХ-ын 2026 оны нөхөн сонгуульд бие даан нэр дэвшигч Энхцэцэгийн Баттөгс.

Тариалан сумын Монгол ардын намын хороо нь 2024 оны орон нутгийн ээлжит сонгуульд оролцсон 5 зорилт, 12 дэд зорилтын хүрээнд 94 арга хэмжээ хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөрт дахин дүгнэлт гаргуулахаар ирүүлж дүгнэлт гаргуулсан. /Тариалан сумын Монгол ардын намын хорооны мөрийн хөтөлбөрт өгсөн дүгнэлт, мөрийн хөтөлбөрийг хавсралт 1-ээр үзүүлэв/

Харин Алаг-Эрдэнэ сумын ИТХ-ын 2026 оны нөхөн сонгуульд бие даан нэр дэвшигч Энхцэцэгийн Баттөгс нь 4 зорилт 45 дэд зорилтын хүрээнд 52 арга хэмжээг хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөрт дүгнэлт гаргуулахаар ирүүлж дүгнэлт гаргуулсан. / Алаг-Эрдэнэ сумын ИТХ-ын 2026 оны нөхөн сонгуульд бие даан нэр дэвшигч Энхцэцэгийн Баттөгсийн мөрийн хөтөлбөрт өгсөн дүгнэлт, мөрийн хөтөлбөрийг хавсралт 2-т үзүүлэв/

Нам, бие даан нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрийг хянахдаа мөрийн хөтөлбөрт заасан арга хэмжээнүүд нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3-т заасан хориглосон арга хэмжээ эсэх, Хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд нийцсэн эсэх, санхүүгийн эх үүсвэрийг бодитой тооцсон эсэхэд хяналт хэрэгжүүлж дүгнэлтийг өгсөн болно.

Мөрийн хөтөлбөрт заасан арга хэмжээнүүдийн санхүүгийн эх үүсвэрийг тооцохдоо нам, бие даан нэр дэвшигч нь шууд бие даан хэрэгжүүлэхээр төлөвлөөгүй, хэрэгжүүлэх боломж бололцоог ашиглаж ажиллахаар мөрийн хөтөлбөртөө тусгасан байх тул нийцсэн дүгнэлтийг өгч ажилласан.

Нийцсэн дүгнэлтүүдийг тухайн сумын сонгуулийн хороо болон нам, эвсэл, бие даан нэр дэвшигчдэд хуулийн хугацаанд хүргүүлнэ.

¹ Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага нь энэ хуульд заасан нам, эвслийн хандивын тайлан, сонгуулийн мөрийн хөтөлбөр болон түүнд хийсэн дүгнэлтийг санал авах өдрөөс 22 хоногийн өмнөөс эхлэн энэ хуульд заасны дагуу нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлангаа хүргүүлэх өдрийг дуустал өөрийн байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт нээлттэйгээр байршуулна.

² Орон нутгийн Хурлын ээлжит бус, нөхөн, дахин сонгуулиар нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь төрийн аудитын дээд байгууллагаас тогтоосон хугацаанд сонгуулийн мөрийн хөтөлбөр болон энэ хуулийн 25.3.6, 25.4.6-д заасан хандивын тайландаа дүгнэлт гаргуулахаар төрийн аудитын байгууллагын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

1. Сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцох намын хороо, бие даан нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөр нь холбогдох хууль, тогтоомжид нийцсэн байна.



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.04.20 № 1/350
танай _____-ны № _____-т

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд заасан
шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөвсгөл аймгийн Тариалан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцох Хөвсгөл аймгийн Тариалан сумын Монгол Ардын намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Хөвсгөл аймгийн Тариалан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь Тариалан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Хөвсгөл аймгийн Тариалан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 20256 оны нөхөн сонгуульд оролцохоор Хөвсгөл аймгийн Тариалан сумын Монгол Ардын намын хорооны ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлага болон холбогдох хууль, тогтоомжид тус тус нийцсэн байна.

Хөвсгөл аймгийн Тариалан сумын Монгол Ардын намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөр/ 16 хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Хөвсгөл аймгийн Тариалан сумын Сонгуулийн хороонд.

Хавсралт 16 хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР





ТАРИАЛАН СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

2026



МОНГОЛ АРДЫН НАМ

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТАРИАЛАН
СУМЫН ИТХ-ЫН 2026 ОНЫ НӨХӨН
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МОНГОЛ АРДЫН
НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР



АГУУЛГА:

НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

1.1.ЭРҮҮЛ МЭНД

1.2.БОЛОВСРОЛ

1.3.СОЁЛ СПОРТ

1.4.НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

2.1. ХАА-Н ҮЙЛДВЭРЛЭЛ

2.2. ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЖИЛТ

2.3. ТӨСӨВ САНХҮҮ, СТАТИСТИК

2.4. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

ГУРАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО:

ДӨРӨВ. ДЭД БҮТЭЦ, СУМЫН ТӨВИЙН ТОХИЖИЛТЫН БОДЛОГО:

4.1. ДЭД БҮТЭЦ

4.2. СУМЫН ТӨВИЙН ТОХИЖИЛТ

ТАВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО:



Сумын МАН-ын хорооны Тэргүүлэгчдийн
2026 оныр сарынөдрийнр тогтоолоор батлав.


**Тариалан сумын ИТХ-ын 2026 оны сонгуульд МАН-аас
дэвшүүлж буй мөрийн хөтөлбөр**

МӨРИЙН ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

- ✓ Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль
- ✓ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- ✓ МУ-ын алсын хараа – 2050 хөгжлийн хөтөлбөр
- ✓ Хөгжсөн Хөвсгөл 2030 хөтөлбөр
- ✓ Хөвсгөл аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл
- ✓ 2024 оны УИХ болон аймгийн ИТХ-ын сонгуульд МАН-аас дэвшүүлсэн мөрийн хөтөлбөр.
- ✓ Тариалан сумын ард иргэдийн санал.

УРИА: “ЖИШИГ СУМЫН ТӨЛӨӨ ХАМТДАА”

ЗОРИЛГО: Орон нутгийнхаа хөгжлийг хурдасгаж, иргэдийнхээ амьдралын чанарыг дээшлүүлж, жишиг сум болоход чиглэгдэнэ.



3.28

0000000000

НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО**Хүний хөгжлийн цогц бодлогыг хэрэгжүүлэнэ.****1.1. ЭРҮҮЛ МЭНДИЙН ТАЛААР:**

- 1.1.1. Орон нутгийн төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудыг бэхжүүлж, эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний чанар, хүртээмж, үр дүнг дээшлүүлж, чадварлаг, ёс зүйтэй хариуцлагатай хүний нөөцийг төлөвшүүлэнэ.
- 1.1.2. Өвчнөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлэгийн үзлэгийн хамрагдалтыг нэмэгдүүлж, эрүүл мэндийн салбарт цахим шилжилтийг эрчимжүүлэнэ.
- 1.1.3. Эрүүл амьдралын хэв маягийг дэмжсэн дасгал хөдөлгөөн, спорт, нийтийн биеийн тамираар хичээллэх, эрүүл зөв хооллох, өвчнөөс урьдчилан сэргийлэх нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээг орон нутагт үр дүнтэй зохион байгуулана.
- 1.1.4. “ЭЛЭГ БҮТЭН МОНГОЛ” “ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ ШҮД” “УМАЙН ХҮЗҮҮН ХАВДАРГҮЙ МОНГОЛ” хөтөлбөрүүдийг орон нутагт үр дүнтэй хэрэгжүүлэнэ.
- 1.1.5. Эрүүл мэндийн төвийн 24 ортой эмнэлэгийн барилгыг ашиглалтанд оруулах, эмнэлэгийн багаж, тоног төхөөрөмж, хатуу зөөлөн эдлэлийг стандартын дагуу болгохыг чухалчилана.
- 1.1.6. Эрүүл мэндийн яаралтай тусламжид шаардлагатай техник хэрэгсэлээр хангаж, бүрэн тоноглогдсон орчин үеийн яаралтай түргэн тусламжийн машинтай болгох талаар асуудлыг холбогдох газарт тавина.
- 1.1.7. Улаанчулуутад нийгмийн эрүүл мэндийн шинэ байрны асуудлыг шийдвэрлэх, хөдөөгийн багуудын эмч нарын унааг шинэчлэх арга хэмжээ авна.

1.1.8. Эмнэлэгийн ажиллагсадын нийгмийн асуудал, ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, тэднийг гадаад дотоодын чадавхижуулах, мэргэшүүлэх сургалтуудад хамруулахыг дэмжинэ.

1.1.9. “Эмийн зохистой хэрэглээ” аяныг жил бүр зохион байгуулж, нэн зайлшгүй шаардлагатай эмийн хангалтыг нэмэгдүүлж, эмийн чанар, аюулгүй байдалд тавих, иргэд олон нийт төрийн хяналтыг сайжруулана.

1.2. Боловсролын талаар:

1.2.1. Сургуулийн өмнөх боловсролд хамрагдвал зохих хүүхдүүдийг бүрэн хамруулж, анги дүүргэлтийг стандартын түвшинд байлгана.

1.2.2. Хүүхэд харах үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, яслийн үйлчилгээг сэргээнэ.

1.2.3. Боловсролын багц хуулийг орон нутагт үр дүнтэй хэрэгжүүлж, цэцэрлэг, сургуулийн орчныг камержуулах, хүүхдийн аюулгүй, ээлтэй суралцах орчныг бүрдүүлэнэ.

1.2.4. Цэцэрлэгийн 90 хүүхдийн барилгад их засвар хийж, гадна талбайн орчны тохижилт, тоглоомжуулалтыг нэмэгдүүлэх, талаар холбогдох газруудад тавина.

1.2.5. Хичээлийн шинэ 960 хүүхдийн барилгыг ашиглалтанд оруулах, анги, танхимуудыг стандартын шаардлагад нийцүүлэх арга хэмжээ авна.

1.2.6. Багш нарын ажлын бодит үнэлэмжийг нэмэгдүүлж, тэднийг гадаад дотоодын сургалтанд хамруулан чадавхижуулах, сургуулийг сэтгэл зүйч, цэцэрлэгийг нийгмийн ажилтантай болгох асуудлыг мэргэжлийн байгууллагуудад тавина



З.Дж

000000005

- 1.2.7. Цэцэрлэгийн хүүхдийн хоол болон сургуулийн үдийн хоолны стандарт, чанарт өөрчлөлт гаргах, орц найрлагыг нэмэгдүүлэх, шим тэжээл, амин дэмээр баялаг хоол, сүү, сүүн бүтээгдэхүүнээр үйлчлэхийг зорино.
- 1.2.8. “Монгол хүн” бэлтгэх бодлогын хүрээнд албан бус боловсролын төвийг ЕБС-ийн дэргэд байгуулах, түүнд хамрах хүрээг өргөжүүлэхийг дэмжинэ.
- 1.2.9. Хичээлээс гадуурхи хүүхдийн сонирхол авьяас чадварыг хөгжүүлэх сонгон, секц, дугуйлангийн үйл ажиллагааг дэмжиж өргөжүүлэнэ.
- 1.2.10. Хөдөөгийн багуудад зуны цэцэрлэгийн байруудыг засварлах, шинэчлэх асуудлыг шийдвэрлэх, орчны тохижилт, аюулгүй байдлыг сайжруулах асуудлыг дэмжин ажиллана.

1.3. Соёл, спортын талаар:

- 1.3.1. Соёл спортын салбарын материаллаг орчин, нөхцлийг дээшлүүлж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, хөгжмийн зэмсэг, спортын хэрэглэлийн хангалтыг сайжруулахыг бодлогоор дэмжинэ.
- 1.3.2. Нийтийн номын сан болон орон нутаг судлах танхимыг орчин үеийн шаардлагад нийцүүлэн тохижуулж, соёлын төвийг мэргэжлийн боловсон хүчнээр бэхжүүлж, чадавхижуулана.
- 1.3.3. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг орон нутагт үр дүнтэй хэрэгжүүлэж, соёлын биет ба биет бус өвийн мэдээллийн санг баяжуулж, хадгалалт хамгаалалтыг сайжруулана.
- 1.3.4. Соёлын төв, соёл спортын цогцолборын барилгад их болон урсгал засвар хийж, үйлчилгээний орчин нөхцөлийг сайжруулан, соёлын төвийг LED дэлгэцтэй болгохыг дээд газарт нь уламжилана.

1.3.5. Хөдөөгийн багуудын “Мэдээллийн төв”-үүдийг засварлан тохижуулж, соёл урлагийн зөөврийн тайзтай болгоно.

1.3.6. Сумын төвд хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх 3х3 сагсан бөмбөг болон хөл бөмбөгийн талбай шинээр байгуулахыг дэмжинэ.

1.4. Нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн талаар:


1.4.1. Хүн амынхаа нийгмийн бүлэг /хүүхэд, залуучууд, ахмад настан, эхчүүд, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд/ бүрт чиглэсэн хөгжлийн бодлого, хөтөлбөр, төслүүдийг орон нутагт үр дүнтэй хэрэгжүүлэнэ.

1.4.2. Амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ядуурлын түвшинг бууруулах бодлого баримтлана.

1.4.3. Төрөөс үзүүлж буй нийгмийн халамж, тусламж үйлчилгээг зөвхөн зорилтод бүлэгт чиглүүлж ажиллана.

1.4.4. Байгалийн баялагийн сангийн тухай хуулийг орон нутагт үр дүнтэй хэрэгжүүлж, иргэн бүрийн нэрийн дансны хуримталалыг арвижуулан, эрүүл мэнд, боловсрол, орон сууцны асуудлаа шийдвэрлэх боломжийг бүрдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэнэ.

1.4.5. Нийгмийн даатгалын шинэчлэлийг үргэлжлүүлж, тэтгэвэр, тэтгэмжийг үнийн өсөлттэй уялдуулан жил бүр нэмэгдүүлэх бодлогыг орон нутагт үр дүнтэй хэрэгжүүлэнэ.



- 1.4.6. Хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, хамгаалалын үйлчилгээг сайжруулан гэр бүл, хүүхэд хөгжил хамгаалалын нийгмийн ажилтантай болохыг дэмжинэ.
- 1.4.7. “Нэг өрх-Нэг ажлын байр” бодлого баримталж, дундаж орлоготой өрхийн тоог нэмэгдүүлж, суманд 500-аас доошгүй ажлын байр шинээр бий болгож, ажилгүйдлийн түвшинг бууруулана.
- 1.4.8. Хөдөөгийн сэргэлт бодлогын хүрээнд баялагын сан, нийгмийн даатгалын сангаар болон ипотека, 3%-ийн зээлээр дамжуулан төр, хувийн хэвшлийн түншлэлээр иргэдээ орон сууцжуулах төрийн бодлогыг сумандаа хэрэгжүүлэнэ.
- 1.4.9. Хөдөлмөр зуслан болон хүүхдийн зуслантай болгох хувийн хэвшлийн үүсгэл санаачлагыг дэмжинэ.

ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

Сумынхаа эдийн засгийн тогтвортой байдлыг хангаж, жижиг дунд үйлдвэржилтийн бодлого баримтлана.

2.1. ХАА-н үйлдвэрлэлийн талаар:

- 2.1.1. ХАА-н үйлдвэрлэлийг эрчимжүүлэх бодлого баримталж, уг салбарт фермерийн аж ахуй болон хоршооллийг бодлогоор дэмжинэ.
- 2.1.2. “Тариалан хөгжил-2025-2035” хөгжлийн дунд хугацааны хөтөлбөр боловсруулж, түүнийг үе шаттайгаар хэрэгжүүлэнэ.
- 2.1.3. “Монгол мал” хөтөлбөр болон “Шинэ хөдөө” төслийн хүрээнд мал сүргээ эрүүлжүүлэх, чанар, ашиг шимийг сайжруулах ажлыг эрчимжүүлэх бодлого баримталж, хувийн мал эмнэлэгүүдийг бэхжүүлэнэ.

2.1.4. Хөдөөгийн сэргэлт бодлогын хүрээнд сумандаа “Шинэ хоршоо” хөдөлгөөнийг өрнүүлж, малчдын боловсрол, эрүүл мэнд, нийгэм соёлын үйлчилгээг хоршоогоор дамжуулан хэрэгжүүлэнэ.

2.1.5. МАА-ын бүтээгдэхүүний /мах, сүү, арьс шир, ноос, ноолуур/ боловсруулалт хийх жижиг, дунд үйлдвэр цехийг бодлогоор дэмжин, зээл төсөл хөтөлбөрт хамруулах арга хэмжээ авна.

2.1.6. Газар тариалангийн эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулж, “Атар-IV” аяныг орон нутагтаа үр дүнтэй хэрэгжүүлэнэ.

2.1.7. Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах, бодлогын хүрээнд “Хүнсний хувьсгал” хөтөлбөрийг орон нутагтаа үргэлжлүүлэн, гол нэр төрлийн бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийг бодлогоор дэмжинэ.


2.1.8. Дөрвөн улирлын хүлэмж, агуулах, зоорийн аж ахуй болон гахай, тахиа, өндөг, зөгийн аж ахуй эрхлэх үүсгэл санаачлагыг бодлогоор дэмжин хөгжүүлэнэ.

2.1.9. Бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд малын тэжээлийн үйлдвэрийг байгуулах бодлогыг баримталж, орон нутгийн өвс тэжээлийн нөөцийг бүрдүүлэх ажлыг хувийн хэвшилтэй хамтран ажиллана.

2.1.10. Малчид, тариаланчид, ногоочдын залгамж халааг бэлтгэх аяныг хэрэгжүүлж, малын эмч, мал зүйч бэлтгэх бодлого баримтлана.

2.2. Жижиг дунд үйлдвэржилтийн бодлогын талаар:

2.2.1. Сумын эдийн засагт нөлөө үзүүлэхүйц, орон нутгийн түүхий эдэд түшиглэсэн томоохон болон жижиг дунд үйлдвэрүүдийг хөгжүүлж, ДНБ үйлдвэрлэлтийг 2023 оныхоос 2 дахин нэмэгдүүлэнэ.



2.2.2. ажлын байр олноор бий болгох, тогтвортой үйл ажиллагаа явуулах дараах үйлдвэрлэлийг бодлогоор дэмжин хөгжүүлэнэ. Үүнд:

- Тоосго, блокны үйлдвэр
- Барилгын материалын үйлдвэр, цех
- Эсгий, эсгий эдлэлийн үйлдвэр.
- Ахуйн үйлчилгээний үйлдвэр.
- Мод боловсруулах, мод модон эдлэлийн үйлдвэр
- Шахмал түлшний үйлдвэр
- МАА-н бүтээгдэхүүний анхан шатны боловсруулалт хийх үйлдвэр.
- Монгол гэр, тавилгын үйлдвэр
- Жимс жимсгэнэ болон хүнсний ногоо нөөцлөх, даршлах үйлдвэр.
- Талх гурилан бүтээгдэхүүний үйлдвэр.


2.2.3. Орон нутагт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг түлхүү хэрэглэхийг иргэддээ уриалж, төрийн худалдан авалтад орон нутгийн үйлдвэр, бизнес эрхлэгчид, баялаг бүтээгчид оролцохийг дэмжинэ.

2.2.4. Тариалан сумын 2025-2028 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулж, уг хөтөлбөрийг энэ 4 жилд үе шаттайгаар хэрэгжүүлэнэ.

2.3. Төсөв, санхүү, статистикийн талаар:

2.3.1. Орон нутгийн татварын бааз суурийг өргөтгөн, төсвийн орлогыг нэмэгдүүлж, орон нутаг бие даан хөгжих бодлогыг баримтлана.

2.3.2. Төсөв санхүүгийн шинэчлэлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлж, санхүүгийн албаны ажилтнуудыг чадавхижуулана.



2.3.3. Төр хувийн хэвшлийн статистик, хүн ам, өрхийн мэдээллийн сангийн баяжилт тооцооллыг сайжруулж, цахим үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэнэ.

2.3.4. төсвийн үр ашиггүй зардлыг танаж, хэмнэлтийн горимыг баримталж, төсвийг үр дүнтэй зарцуулана.

2.3.5. Орон нутагт хөрөнгө оруулалтыг оновчтой төлөвлөж, Хоршоо хөгжүүлэх сан болон орон нутгийн хөгжлийн сан бусад сангуудын үйл ажиллагааг хуулийн хүрээнд зохион байгуулана.

2.4. Аялал жуулчлалын талаар:

2.4.1. Аялал жуулчлалыг сумын эдийн засгийн туслах салбарын нэг болгон хөгжүүлэх хөтөлбөр гарган хэрэгжүүлэнэ.

2.4.2. Аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг сумандаа бий болгох түүх, соёлын болон орон нутагтай танилцах аялал жуулчлалыг дэмжин хөгжүүлэнэ.

2.4.3. Аялал жуулчлалын гол зам буюу намнангийн ар болон зүлэгт чиглэлд жуулчны отог байгуулах, алжаал тайлах цэг, үйлчилгээний газар, төвүүдийг олон улсын стандартад нийцүүлэн байгуулахийг дэмжинэ.

ГУРАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО:

Байгаль орчноо унаган төрхөөр нь хадгалан өвлүүлэх, эко системийн тэнцвэрт байдлыг хангахыг чухалчилна.

3.1.1. Байгаль орчныг хамгаалах, нөөцийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээхэд нутгийн иргэд, олон нийтэд түшиглэсэн менежментийг хэрэгжүүлэнэ.

3.1.2. “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг орон нутагт эрчимжүүлж, айл өрх бүр эзэмшлийн газартаа мод тарих аяныг өрнүүлж, бодлогоор дэмжинэ.

3.1.3. Ойн хөнөөлт шавьжтай тэмцэх, ойн түймэрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах менежментийг сайжруулж, мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор түүнтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэнэ.

3.1.4. Ус, хөрс, орчны бохирдолыг багасгах, түүнтэй хийх тэмцэлд төр, олон нийт, иргэдийн оролцоо, хяналтыг өндөржүүлж, ногоон байгууламжтай талбайн хэмжээг нэмэгдүүлэнэ.

3.1.5. Ган, зуд, гал түймэр, үер, газар хөдлөлт зэрэг байгалийн гамшигаас сэргийлэх, болзошгүй эрсдэлийг бууруулах, ажлын шинэ менежментийг хэрэгжүүлэнэ.

3.1.6. Бэлчээрийг усжуулах, худагжуулах ажлыг үргэлжлүүлэн, малын бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлэн, бэлчээр ашиглалтын журам гарган, малчдыг хариуцлагажуулана.

3.1.7. Голуудын хамгаалалтын зурвасыг шинэчлэн тогтоож, амралт, чөлөөт цагаа өнгөрүүлэх отог байгууламжийг Нялуу, бичигт хад орчимд хувийн хэвшлийн оролцоотойгоор бий болгохыг дэмжинэ.

3.1.8. Цаг-уурын өртөөг бэхжүүлж, цаг агаарын мэдээ, мэдээллийг олон нийтэд шуурхай хүргэх, түгээх ажлын чанар, хүртээмжийг дээшлүүлэнэ.

ДӨРӨВ. ДЭД БҮТЭЦ, СУМЫН ТӨВИЙН ТОХИЖИЛТЫН

БОДЛОГО:

Сумын төвийг төлөвлөлттэйгээр хөгжүүлж, иргэдийн ая тухтай орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэхийг зорино.

4.1. Дэд бүтцийн талаар:

4.1.1. Сумын хөгжлийн “Жишиг сум” төслийн зураг төсөв, ТЭЗҮ-ийг хийлгэх, уг төслийг 2026 оноос эхлүүлэх арга хэмжээ авна.

4.1.2. Иргэд, аж ахуйн нэгжүүдэд газар эзэмшүүлэх, өмчлүүлэх ажлыг хуулийн хүрээнд төлөвлөлтийн дагуу олгох, гэр бүлийн хэрэгцээний газар өмчлөлийг нэмэгдүүлэнэ.

4.1.3. НАҮТ-ийн дулаан түгээх магистраль шугам, зуухны тогоо, усан сангуудыг шинэчилэх, хүчин чадлыг нэмэгдүүлэх, зуухны янданг утаа шүүгчтэй болгох, орчны бохирдолыг бууруулах арга хэмжээ авна.


4.1.4. Газар зохион байгуулалтын төлөвлөлтийн дагуу шинээр буй болж байгаа суурьшлийн бүсийн айл өрх, үйлчилгээний газруудыг цахилгаанаар хангах арга хэмжээ авна.

4.1.5. Сумын төвийн доторхи цахилгааны О4-ын шугамыг төмөр бетонон тулгууртай сип шугамаар солих, трансформаторуудыг шинэчилэх асуудлыг мэргэжлийн газруудаар шийдвэрлэх арга хэмжээ авна.

4.1.6. Сумын төв доторхи замуудыг засч, сайжруулан, 1.2км бетонон зам шинээр байгуулах, соёл спортын цогцолбороос хүүхдийн цэцэрлэг хүртэл бетонон зам болон явган хүний зам тавих, тэмдэгжүүлэх үүсгэл санаачлагыг дэмжин ажиллана.

4.1.7. Хөдөөгийн багуудад хүчин чадал сайтай 4G сүлжээ бий болгож, хот айл, иргэдийн үүсгэл санаачилгаар “Starlink” үйлчилгээг нэвтрүүлж, Баянхошуу багийн энгэрийн бэлийн сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлэх арга хэмжээ авна.

4.1.8. Орон нутгийн чанартай зам даваануудыг засч сайжруулан, тэмдэгжүүлж, аюулгүй байдлыг хангахад анхаарна.



З. Дорж

0000000013

4.1.9. Сумын хилийн цэс, нутгийн зарим маргаантай заагуудын зэргэлдээх аймаг сумдын удирдлагуудтай тохиролцож, засгийн газарт тавьж шийдвэрлүүлэнэ.

4.2. Сумын төвийн тохижилтын талаар:

4.2.1. “Хашаандаа сайхан амьдарцгаая” хөдөлгөөн өрнүүлж, гудамж, хэсгүүдийг эмх цэгцтэй болгож, “Жишиг гудамж” төсөл хэрэгжүүлэнэ.

4.2.2. Хүн амын ундны усны хангамж, аюулгүй байдлыг сайжруулах, ухаалаг худгийн тоог нэмэгдүүлэх, ундны усны бүх худагуудыг ус зөөлрүүлэгчтэй болгохыг зорино.

4.2.3. Сумын төвийн замуудад арчлалт тордолт хийх, тэмдэг тэмдэглэгээг шинэчилэх, гэрэлтүүлэг, хяналтын камеруудыг нэмэгдүүлэх, сумын төвийн бетонон зам дагуу гоёлын гэрлэн чимэглэлтэй болгох арга хэмжээ авна.

4.2.4. Хог хаягдлыг ялгах, дахин боловсруулах, байгальд ээлтэй аргаар устгах технологи, менежментийг судлан хэрэгжүүлэнэ.


4.2.5. Айл өрхүүдэд био жорлон, бохирын байгууламж байгуулах замаар нүхэн жорлонгоос татгалзах хөдөлгөөн өрнүүлж, хөрсний бохирдолыг бууруулана.

4.2.6. Золбин нохой, муур устгалт, хог цэвэрлэгээ, тээвэрлэлтийн ажлыг тогтмолжуулж, хууль журмуудын хэрэгжилтийг ханган ажиллана.

4.2.7. Шивэрт болон Улаан чулуутын голын авто замын болон явган хүний гүүрнүүдийг засварлаж, орчны аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авна.

4.2.8. Өвлийн улиралд сумын төвөөс алслагдсан газруудад бага оврийн автобус, таксины үйлчилгээ эрхлэх үүсгэл санаачлагыг дэмжинэ.

4.2.9. Сумын төвөөс малтай иргэдийг гаргах, малчны хороолол бий болгон суурьшуулах асуудлаар иргэдийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулж шийдвэрлэнэ.



4.2.10. Улиралын чанартай хүнс, бараа материал борлуулах төвлөрсөн цэг талбайтай болох журам гарган хэрэгжүүлж, ил задгай худалдааг цэгцлэнэ.

ТАВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО:

Төрийн албыг хүний эрхийг дээдэлсэн, ил тод нээлттэй, мэргэшсэн, чадварлаг, ёс зүйтэй, хариуцлагатай алба болгон төлөвшүүлэнэ.

5.1.1. Төрийн албаны аливаа шийдвэр гаргалтад хүний эрхийн мэдрэмжтэй хандаж, хүний эрхийг хангах үндэсний II хөтөлбөрийг орон нутагт үр дүнтэй хэрэгжүүлэнэ.

5.1.2. Нутгийн захиргааны байгууллагын тогтоол, шийдвэр, гэрээ хэлцэл, мэдээллийн санг олон нийтэд нээлттэй, ил тод болгоно.


5.1.3. Орон нутагт авлигатай тэмцэх, шударга бус зүйлийг үл тэвчих сэтгэлгээ хандлагыг бүх нийтэд төлөвшүүлэнэ.

5.1.4. Төрийн албаны бүх шатанд хүний нөөцийн чадавхыг бэхжүүлж, тэдний нийгмийн баталгааны бодлогыг үе шаттайгаар хэрэгжүүлэнэ.

5.1.5. Төрийн бүх үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэхийг чухалчилж, “Ухаалаг E-mongolia” системийн хүртээмжийг нэмэгдүүлж, “ХУР-ДАН” төвийн үйлчилгээг нэвтрүүлэнэ.

5.1.6. Төрийн үйлчилгээнд процессын дахин инженерчлэл хийж, аливаа шат дамжлагыг бууруулж, иргэд бизнест шуурхай чадварлаг, чанартай үйлчилгээ үзүүлэхийг эрхэмлэнэ.

5.1.7. Төрийн албан хаагчдын ажлын хариуцлага, үр дүнг үнэлэх гүйцэтгэлийн үнэлгээний тогтолцоог үр дүнтэй нэвтрүүлэнэ.



5.1.8. Нийгмийн дэг журам хангах, гэмт хэрэг зөөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх, талаар 2025-2028 оны төлөвлөгөө гарган, түүнийг үе шаттай хэрэгжүүлэнэ.

5.1.9. Нутгийн захиргааны барилгад өргөтгөл хийж, ус ариун цэврийн байгууламжтай болгохыг чухалчилана.

5.1.10. Гал унтраах 46-р ангийн депогийн байрыг шинээр барих асуудлыг мэргэжлийн байгууллагуудад тавьж уламжилана.

5.1.11. Төр хувийн хэвшлийн түншлэл, болон ТББ-ын үйл ажиллагааг төрөөс дэмжиж төрийн зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх зарчим баримтлана.

ТАРИАЛАН СУМЫН
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО





ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.05.08 № 1/387
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН
АЛАГ-ЭРДЭНЭ СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2026
ОНЫ НӨХӨН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ
ЭНХЦЭЦЭГИЙН БАТТӨГС ТАНАА

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч Энхцэцэгийн Баттөгсийн ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь Алаг-Эрдэнэ сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч Энхцэцэгийн Баттөгс/РД:РХ93041235/-ийн ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлага болон холбогдох хууль, тогтоомжид тус тус нийцсэн байна.

Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч Энхцэцэгийн Баттөгсийн сонгуулийн мөрийн хөтөлбөр/...⁵... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын Сонгуулийн хороонд.

Хавсралт ⁵... хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

**АЛАГ-ЭРДЭНЭ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН 2026 ОНЫ НӨХӨН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ ЭНХЦЭЦЭГИЙН БАТТӨГСНИЙН
“БҮТЭЭЛЧ АЛАГ-ЭРДЭНЭЧҮҮД” МӨРИЙН ХӨТӨЛБӨР**
/2026-2028 он/

АЛАГ-ЭРДЭНЭ СУМ
2026 он



3.284

АЛАГ-ЭРДЭНЭ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН 2026 ОНЫ НӨХӨН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ ЭНХЦЭЦЭГИЙН БАТТӨГСНИЙ
“БҮТЭЭЛЧ АЛАГ-ЭРДЭНЭЧҮҮД” МӨРИЙН ХӨТӨЛБӨР

ҮНДЭСЛЭЛ:

- “Алсын хараа 2050” МОНГОЛ Улсын урт хугацааны хөгжлийн хөтөлбөр
- “ХӨГЖСӨН ХӨВСГӨЛ-2030” хөтөлбөр
- МОНГОЛ УЛСЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ-2030
- БҮТЭЭЛЧ ХӨВСГӨЛЧҮҮД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль

Уриа: “ХӨГЖЛИЙН хөтөлбөрийг ХАМТДАА хэрэгжүүлье”

“Би биш бид”

Зорилго: Хүн төвтэй, хүний эрхийг дээдэлсэн, иргэдийн хангалуун амьдрах, аж ахуйн нэгжийн хөгжих боломжийг дэмжсэн ХӨГЖЛИЙН хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

Үр дүн: АМЬДРАЛЫН ЧАНАР

АЯ ТУХТАЙ АМЬДРАЛ

АЮУЛГҮЙ ОРЧИН

Нэг: ХҮНИЙ ХӨГЖИЛ

1.1 Хүүхэд бидний – ИРЭЭДҮЙ, ЗАЛУУС БИДНИЙ ИТГЭЛ

1.1.1 Зуны цэцэрлэг, Хүүхэд харах үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж үргэлжлэх хугацааг уртасган, чанарыг сайжруулахад иргэд, хувийн хэвшлийг дэмжиж ажиллана.

1.1.2 Шинээр баригдаж буй сургуулийн барилгыг ашиглалтад оруулахад анхаарч ажиллана.

1.1.3 ЕБС-ийн биеийн тамир, спортын “**ГАДНА ЦОГЦОЛБОР ТАЛБАЙ**”-г шинэчлэн стандартын дагуу бүрэн тохижуулахад анхаарч ажиллана.


1.1.4 Бүсийн эдийн засгийн тэргүүлэх чиглэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан нутгийн иргэдийг их, дээд сургууль, мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагад суралцуулах ажлыг зохион байгуулна.

1.1.5 Цэцэрлэг, сургуулийн үдийн хоолонд сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж малчдын орлогын тогтвортой байдлыг хангах арга хэмжээ авна.

1.2 Эмэгтэйчүүд бидний -ТҮШИГ

1.2.1 Эмэгтэйчүүдийн үүсгэл санаачилгын клуб, холбоо ТББ-уудийг бодлогоор дэмжинэ.

3. 



1.2.2 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зээл бусад төсөл хөтөлбөрүүдээс санхүүждэг зээл тусламжийн тодорхой хувийг ганц бие, өрх толгойлсон эмэгтэйчүүдийг дэмжихэд чиглүүлэх арга хэмжээ авна.

1.2.3 “Гэр бүлд зөвлөгөө өгөх танхим”-ыг суманд байгуулж, бүх нийтийн соён гэгээрэл, гэр бүлийн боловсролыг дээшлүүлэх, зөвлөн туслах үйлчилгээний орчин, нөхцөл, хамтын ажиллагааг сайжруулахад анхаарч ажиллана.

1.3 Ахмадууд бидний - БАХАРХАЛ

1.3.1 Ахмадууд чөлөөт цагаа өнгөрүүлэх, сэргээн засаж чийрэгжүүлэх төвийн үйл ажиллагааны чанар хүртээмжийг сайжруулна.

1.3.2 Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, орлогыг нэмэгдүүлэх, мэдлэг туршлагаа залуучуудад өвлүүлж үлдээх нөхцөлийг бүрдүүлнэ

“Баялаг бүтээгчид бидний – ХӨГЖИЛ”

Баялаг бүтээгчдээ дэмжих:

1.4.1 “Баялаг Бүтээгч” хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.

1.4.2 Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг бүх түвшинд нэмэгдүүлж авлига, хүнд суртлаас ангид, иргэдийн сэтгэлд хүрсэн үйлчилгээг бий болгоно.

1.4.3 Баялаг бүтээгчдээ төрийн болон төсөл, хөтөлбөрийн эх үүсвэртэй хөнгөлөлтэй зээл, тусламжид хамруулахад дэмжлэг үзүүлж ажиллана.

1.5 Малчдаа дэмжих:

1.5.1 “Залуу Малчин” хөтөлбөрийг хэрэгжүүлж, хөдөөгийн залуусаа дэмжинэ.

1.5.2 Малын гаралтай түүхий эдээр ахуйн түвшинд үйлдвэрлэл эрхлэх төсөл, хөтөлбөрийг дэмжиж ажиллана.

1.5.3 Малчдын хоршоо, нөхөрлөлүүдийг чадавхжуулах, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх, төсөл, хөтөлбөрт хамруулахад анхаарч ажиллана.

1.5.4 Төмс хүнсний ногоо тарих талбай, усан хангамж, хүлэмж, зоорьтой болоход иргэд, хоршоодод дэмжлэг үзүүлэх замаар төмс, хүнсний ногоогоор сумын хэрэгцээний тодорхой хувийг хангадаг болох зорилт тавин ажиллана.

1.5.5 Баг бүрд мал ариутгалын ДУК машинтай болох санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлүүлж ажиллана.

Хоёр: ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧНЫ ХӨГЖИЛ

2.1 Ая тухтай орчин - НОГООН ХӨГЖИЛ

2.1.1 “Хашаандаа тохилог сайхан амьдарцгаая” хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх арга хэмжээг авна.

2.2 Аж төрөхөд таатай - ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ

2.2.1 Хувийн хэвшлийн оролцоотой орон сууц, хаус хороолол барих асуудлыг дэмжинэ.

2.2.2 Эгийн голын модон гүүрийг Бетонон гүүр болгох -70 м болгох хөрөнгө оруулалтыг татах ажлыг зохион байгуулна.

2.2.3 Мөрөн Хатгал чиглэлийн 1001 замаас Алаг-Эрдэнэ сум орох 3,5 км хатуу хучилттай зам тавих санхүүжилтийг шийдвэрлүүлж ажиллана.

2.2.4 Эрчим хүчний дэд станцтай болох олон талт санал санаачилга гаргаж ажиллана.

2.2.5 Хөв цөөрөмтэй болох ажлыг зохион байгуулна.

3. *Д/у*

1720090001 4. 9070605

0000000000

2.2.6 Хогийн цэгийг орчин үеийн стандартад нийцүүлэх асуудлыг шийдвэрлүүлнэ.

ГУРАВ: ХҮРТЭЭМЖТЭЙ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

3.1 “Эрүүл Монгол хүн” эрүүл мэндийн үйлчилгээ:

3.1.1 “Эрүүл иргэн” эрүүл мэндийн явуулын тусламж үйлчилгээг зохион байгуулж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг иргэдэд ойртуулна.

3.1.2 Эрүүл амьдралын хэв маягийг дэмжсэн дасгал хөдөлгөөн, спорт, нийтийн биеийн тамираар хичээллэх, эрүүл, зөв хооллох, өвчнөөс урьдчилсан сэргийлэх нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэхэд анхаарч ажиллана.

3.1.3 Эмч, сувилагч, мэргэшсэн асрахуйн ажилтан гадаад, дотоодод бэлтгэх бодлого баримтална.

3.1.4 “Элэг бүтэн Монгол”, хүүхдийн “Эрүүл шүд”, “Умайн хүзүүн хавдаргүй Монгол” хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн ажиллаж сумандаа шүдний эмчтэй болох талаар арга хэмжээ авч ажиллана.

3.1.5 Сумын Эрүүл мэндийн төвийн их засвар, сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болох ажлыг орон нутгийн төсвөөс шийдвэрлэх арга хэмжээ авна.

3.1.6 Анхан болон лавлагаа шатлалын эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагын барилга байгууламж, дэд бүтэц, тоног төхөөрөмжийг шинэчлэн, стандарт, чанарын шаардлага хангасан тэгш, хүртээмжтэй, чанартай үйлчилгээг үзүүлэх орчныг бүрдүүлж, бүрэн тоноглогдсон хэвтрийн үйлчлүүлэгч зөөвөрлөх автомашинтай болоход бүх талын хөрөнгө оруулалтыг татах ажлыг зохион байгуулна.

3.2 Оюунлаг Хөвсгөлчүүд - Боловсрол, Соёлын үйлчилгээ.

3.2.1 Гадаад хэлний сургалтын хэрэглэгдэхүүнийг сайжруулахад анхаарч аялал жуулчлалтай холбож хөгжүүлнэ.

3.2.2 Нийтийн номын санг цахим хэлбэрт шилжүүлж, орчин үеийн шаардлагад нийцүүлэн хөгжүүлж, хүний нөөцийг чадавхжуулахад анхаарч ажиллана.

3.2.3 Соёлын аялал жуулчлал, соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.

3.2.4 Үндэсний өв уламжлал, түүх, уран зохиол, нүүдлийн ахуй соёлыг шингээсэн хөтөлбөр, уран бүтээл, дижитал контент бүтээгчдийг дэмжиж, соёлын боловсролтой, эерэг хандлагатай, бүтээлч иргэдийг төлөвшүүлэх ажлыг зохион байгуулна.

3.2.5 Баг бүрд улирал тутам соён гэгээрүүлэх үйл ажиллагааг тогтмол зохион байгуулна.

3.3 Зорилтод бүлэгт чиглэсэн нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр

3.3.1 Нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт чиглүүлэх, чанар, хүртээмжийг сайжруулах ажлыг хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын тусламжтайгаар хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

3.3.2 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн суралцах, ажиллах эрхийг хангахад санал санаачилга гаргаж ажиллана.

3.3.3 “Ажилтай иргэн - Амьжиргаатай өрх” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

3.4 Төрийн үйлчилгээ

3. Д/у

1720090001 + 9070605

0000000004

3.4.1 Төрийн үйлчилгээг цахимаар авах иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх, мэдээлэл хүргэх ажлыг тогтмол хэрэгжүүлнэ.

3.5 Иргэдийн оролцоо:

3.5.1 Багийн төвийг ажиллуулан төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.5.2 Багийг хүний нөөц, хөрөнгө санхүүгийн хувьд бэхжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг боловсруулна.

3.5.3 Иргэдийнхээ үүсгэл санаачилгаар байгуулагдсан иргэний нийгмийн байгууллага, холбоо, нөхөрлөл, хоршооны үйл ажиллагааг бодлогоор дэмжиж ажиллана.

ДӨРӨВ:ХӨГЖИЛД ХӨТӨЛСӨН ҮЙЛДВЭРЖИЛТ

4.1 Үйлдвэржилт –ХӨГЖЛИЙН БОЛОМЖ

4.1.1 Орон нутгийн түүхий эдийг ашиглан нэмүү өртөг шингээж импортыг орлосон экспортод чиглэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрлэлийг бүх талаар дэмжинэ.

4.1.3 Үйлдвэр эрхлэгчдийг хөнгөлөлттэй зээлд хамрагдахад бүх талын дэмжлэг үзүүлнэ.

4.2 Аялал жуулчлал- ХӨГЖЛИЙН ГАРЦ

4.2.1 Аялал жуулчлалын гол чиглэлийн зам дагуу ариун цэврийн байгууламж, түр буудаллах, алжаал тайлах цэгүүдийг барьж байгуулан нутгийн иргэдийг ажлын байраар хангах ажлыг хувийн хэвшлийн оролцоотой хэрэгжүүлнэ. /Хөх баавгай үүр/

4.2.2 Зам дагуух газруудыг эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг зохион байгуулна.

4.2.3 Аялал жуулчлалын голлох зам, амрах өртөө, түр отоглох цэг, эко ОО байгуулах ажлыг орон нутгийн төсвөөс шийдвэрлүүлнэ.

4.2.4 Орон нутгийн онцлогт тохирсон брэнд бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл, чанар, дизайныг сайжруулан, хөгжүүлж, орон нутагт орох орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлж нутгийн брэнд бүтээгдэхүүн худалдаалах цэгийг тогтвортой ажиллахад анхаарч ажиллана.

4.3 Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл- ХӨГЖЛИЙН ТУЛГУУР

4.3.1 Малчдын нэгдэх, хорших үйл ажиллагааг дэмжин “ШИНЭ ХОРШОО” хөдөлгөөнийг өрнүүлж, хоршооллыг дэмжинэ.

4.3.2 Соёлын бүтээгдэхүүн, контентыг аялал жуулчлалтай хослуулан хөгжүүлэх, нүүдлийн мал ахуйд суурилсан аялал жуулчлалыг сурталчлан таниулах арга хэмжээг зохион байгуулна.

4.3.3 Малчдад өвөлжөө, хаваржааны газрыг урт хугацаатай эзэмших, ашиглах, тэжээлийн ургамал тариалах боломжийг бий болгоход анхаарч ажиллана.

АЛАГ-ЭРДЭНЭ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН 2026 ОНЫ НӨХӨН СОНГУУЛЬД БИЕ ДААН
НЭР ДЭВШИГЧ Э.БАТТӨГС

3. *Этг*

0000000005

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2026 оны нөхөн сонгуульд Алаг-Эрдэнэ сум Хатгал тосгоны иргэн Энхцэцэгийн Баттөгс миний бие бие даан нэр дэвших хүсэлтэй байгаа тул Бүтээлч Алаг-Эрдэнэчүүд мөрийн хөтөлбөрт Аудитын дүгнэлт гаргаж өгнө үү.

ХҮСЭЛТ ГАРГАСАН: *Э. Баттөгс* Э.БАТТӨГС